



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1/110

Цагаантолгой

Өвөлжилтийн бэлтгэл ажил хангуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1.23, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 02 тоот албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангуулах, өвөлжилт, хаваржилтыг гарз хохиролгүй даван туулах, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж үр дүнг тооцох ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч- Б.Мөнх-Эрдэнэ-(Засаг даргын орлогч)

Нарийн бичиг-З.Цолмон-(ХАА-н тасгийн дарга)

Гишүүдэд – Б. Золбаяр-(Хушаат багийн Засаг дарга)

Л. Сэлэнгэсайхан-(Ивэн багийн Засаг дарга)

З.Оюунсүрэн-(ЖДҮХХ хариуцсан мэргэжилтэн)

А. Батдорж-(БОХУБ)

Ц.Батсайхан-(Газрын даамал)

Г.Ганжолоо-(Ивэн багийн байгаль хамгаалагч)

Ч.Төгсбаатар-(Хушаат багийн байгаль хамгаалагч)

Г.Анхбаяр-(Тархвар зүйч)

Э.Очгэрэл-(Эрүүл мэндийн төвийн дарга)

Д. Өлзийбадрах -(ЕБС-ийн захирал)

Л. Хүрэлмаа-(1-р Цэцэрлэгийн эрхлэгч)

Л. Отгонжаргал-(Энэржи плас инженеринг ХХК-ны менежер)

2. Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг хавсралт №01-ээр, төв суурины өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг хавсралт №02-оор тус тус баталсугай.

3. Өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлыг ААН, албан байгууллага, айл өрх нэг бүрийг хамруулах ажлыг зохион байгуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Б.Мөнх-Агва.
Хянасан: Ч. Агва.
Хувь: 2.
Огноо: 2022.08.09.